



“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/136

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 340 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын хэсгийн ажиллах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журам”-ыг 2 дугаар хавсралтаар, “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын бүртгэлийн хяналтын журам”-ыг 3 дугаар хавсралтаар, “Үйлдвэрийн бүсэд замын хөдөлгөөнд оролцох журам”-ыг 4 дүгээр хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээний журам”-ыг 5 дугаар хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заварчилгаа өгөх журам”-ыг 6 дугаар хавсралтаар, “Яаралтай тусламжийн нэгжийн ажиллах журам”-ыг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дээрх журмуудыг “Таван толгой түлш” ХХК-ийн нийт ажилтан албан тушаалтан, гэрээт болон туслан гүйцэтгэгч байгууллага, тэдгээрийн ажилтнууд батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Дээрх журмуудын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хууль эрхзүй, аудитын алба болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын хэсэгт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.ГАНБААТАР



Үйлдвэрийн бусад
замын хөдөлгөөнд
оролцох журам

СҮАЖ-ҮБЗХОЖ-
008

Хувилбар: 1

Тушаал №

A/136


БАТЛАВ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАД
/...../ М.Ганбаатар

Баталсан өгчор:
2019 он 11 сар 02 өдөр



ҮЙЛДВЭРИЙН БҮСЭД ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХ ЖУРАМ

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		Д.Батбаатар	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан	ХАБЭА-н бүртгэл хяналтын ажилтан	
		М.Баярцэнгэл		

	Үйлдвэрийн бүсэд замын хөдөлгөөнд оролцох журам	СУАЖ-ҮБЗХОЖ- 008	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2019 он сар өдөр
		Тушаал №	

ҮЙЛДВЭРИЙН БҮСЭД ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХ ЖУРАМ

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	Л.Батбаяр	ХЭЗА-н албаны дарга	Тэмдэг
	/...../	М.Анхныбаяр	ХАБЭА-н хэлтсийн дарга	
Боловсруулсан:	/...../	Л. Ширжанцан	ХАБЭА-н ахлах ажилтан	

Үйлдвэрийн бүсэд замын хөдөлгөөнд оролцох журам	СҮАЖ-ҮБЗХОЖ-008
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Үйлдвэрийн бүсэд замын хөдөлгөөнд оролцох журам	СҮАЖ-ҮБЗХОЖ-008
	Хувилбар: 1

АГУУЛГА

Нэг. Зорилго	3
Хоёр. Хамрах хүрээ	3
Гурав. Хамаарах талууд	3
Дөрөв. Үндэслэл.....	3
Тав. Норматив иш татсан баримт	3
Зургаа. Үндсэн хэсэг	4
Долоо. Журмын хэрэгжилт, үүрэг хариуцлага	5

Үйлдвэрийн бүсэд замын хөдөлгөөнд оролцох журам	СҮАЖ-ҮБЗХОЖ-008
	Хувилбар: 1

Нэг. Зорилго

1.1. “ТТТ” ХХК-ийн үйлдвэрийн бүсэд хөдлөх бүрэлдэхүүн замын хөдөлгөөнд оролцох аюулгүй байдлыг хангах, техникийн бүрэн бүтэн байдал, үйлдвэрийн бүсэд хөдөлгөөний соёл хэм хэмжээг, холбогдох дүрэм журмаар зохицуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. “ТТТ” ХХК-ийн үйлдвэрийн бүсэд хөдөлгөөнд оролцож байгаа өөрөө явагч бүх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм тээврийн хэрэгсэл хариуцсан эрх бүхий албан тушаалтан, гэрээгээр ажил үүрэг гүйцэтгэж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд, хамаарна.

Гурав. Хамаарах талууд

3.1. “ТТТ” ХХК-ийн нийт ажилтнууд, гэрээгээр бараа нийлүүлэгч, ажил гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгч хувь хүн, аж ахуйн нэгжүүдэд хамаарна.

Дөрөв. Үндэслэл

Хүснэгт 1

д/д	Баримт бичгийн нэр	Дугаар
1	Үйлдвэрийн бүсэд замын хөдөлгөөн оролцох журам	
2		

Тав. Норматив иш татсан баримт

5.1. Хөдөлмөрийн тухай хууль

5.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль

5.3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

5.4. Зохиц стандартын үзүүлэлт, шаардлагаас ишлэл хийх, эсвэл иш татаж жагсааж бичих аль ч тохиолдолд дараахь стандартууд нь хамгийн сүүлчийн норматив баримт бичиг байх шаардлагатай.

- 1) MNS 4601:98, Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүн, техникийн үйлчилгээ, засварын тогтолцоо, тодорхойлолт
- 2) MNS 4598:98, Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлага
- 3) MNS 5011:2001, Автотээврийн хэрэгслийн техникийн байдлын үзлэг хийх заавар, ерөнхий шаардлага

Үйлдвэрийн бүсэд замын хөдөлгөөнд оролцох журам	СҮАЖ-ҮБЗХОЖ-008
	Хувилбар: 1

- 4) MNS 5013:2001, Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашины утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
- 5) MNS 5014:2001, Дизель хөдөлгүүртэй автомашины утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга

Зургаа. Үндсэн хэсэг

6.1. Үйлдвэрийн дотор болон гадаа талбайд хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулах эрх бүхий хүчин төгөлдөр бичиг баримттай авто машин механизм, ХАБЭА-н хяналтын хэсгээс нэвтрэх зөвшөөрөл авч, харуул хамгаалалтын алба нягтлан шалгаж нэвтрүүлнэ.

6.2. Үйлдвэрийн бүсэд бараа материал ачих, өргөн тээвэрлэх ажил, үүрэг гүйцэтгэх бол хүнд машин, механизм хариуцсан инженер техникийн ажилтнаас "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа" авч ажиллана.

6.3. Үйлдвэрийн бүсэд хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгсэл нь дараах зааврыг мөрдөнө.

6.3.1. Техникийн бүрэн бүтэн байдлыг шалгах механикаар шалгуулсан байна.

6.3.2. Тээврийн хэрэгслийн оврын, ойрын гэрэл асааж тусгайлан анхааруулах шаардлагатай үед ослын дохио ажиллуулж хөдөлгөөнд оролцоно.

6.3.3. Хөдөлгөөнд оролцохын өмнө дуут дохио нэг удаа уртаар өгч оролцоно.

6.3.4. Хөдөлгөөнд ухрах үйлдэл хийх үедээ дуут дохио хоёр удаа уртаар өгч оролцоно.

6.3.5. Замын тэмдэг тэмдэглэгээг дагаж мөрдөнө.

6.3.6. Зогс тэмдэг байгаа зурваст зогсож, саад байгаа бол өнгөрөх хүртэл хүлээх.

6.3.7. Зогсоолд парклах үедээ ухрах үйлдэл хийж зогсоно.

6.3.8. Өргөн тээвэрлэх ажилбар дээр хэрэглэгдэх туслах хэрэгсэл ган татлага, нэхмэл татлага туршигдаж баталгаажсан байна.

Үйлдвэрийн бүсэд замын хөдөлгөөнд оролцох журам	СҮАЖ-ҮБЗХОЖ-008
	Хувилбар: 1

6.3.9. Авто кран, машинт кран, өргөгч сагс зэрэг тусгай тоноглолтой тээврийн хэрэгсэл нь эрх бүхий байгууллагаар орж туршигдсан, бичиг баримтаар баталгаажсан байх бөгөөд тухайн техникийг ажиллуулах эрхийн үнэмлэх бүхий оператор жолооч хийнэ.

6.3.10. Өөрөө явагч тээврийн хэрэгслийн тэвшин дээр хүн тээвэрлэхгүй байх.

6.3.11. Үйлдвэрийн “А” бүсэд нэвтрэх техник хэрэгсэл нь Хяналтын хэсгээс зөвшөөрөл авсан байна.

6.3.12. Үйлдвэрийн “А” бүсэд нэвтрэх зөвшөөрөлтэй тээврийн хэрэгсэл нь ХАБЭА-н хяналтын ажилтанд бүртгүүлж бичиг баримтаа шалгуулж нэвтэрнэ.

6.3.13. Үйлдвэрийн хашаанд байгаа автомашины зогсоолд харуулын албанд бүртгэгдсэн инженер техникийн ажилтнуудын автомашиныг парклана.

6.3.14. Үйлдвэрийн бүсэд нэвтрэх зөвшөөрөлгүй ажилтнуудын автомашин үйлдвэрийн гадна зогсоолд парклана.

6.3.15. Үйлдвэрлэлийн дотор замд хөдөлгөөнд оролцохдоо гүйцэж түрүүлэхийг хатуу хориглоно.

6.3.16. Тээврийн хэрэгсэл нь 4-р постны хөдөлгөөнд саад учруулж зогсохыг шууд хориглоно.

6.3.17. Үйлдвэрийн бүсэд 5км/цагаас илүү хурдтай явж 2-с дээш удаа ХАБЭА-н ажилтнууд болон ИТА нараас анхааруулга (дүрсжүүлсэн баримттай) авсан тээврийн хэрэгслийг дахин нэвтрүүлэхгүй.

6.3.18. Барилга байгууламж өмч хөрөнгийг эвдэж гэмтээхээс сэргийлэх үүрэгтэй. Хэрэв өмч хөрөнгө, тоног төхөөрөмж эвдэж гэмтээсэн осол гаргасан тохиолдолд жолооч оператор нь ослын газраас тээврийн хэрэгслийг хөдөлгөлгүй байлгаж ахлах ажилтан ХАБЭА-н хяналтын хэсэгт мэдэгдэх, үүрэг хүлээнэ.

Долоо. Журмын хэрэгжилт, үүрэг хариуцлага

7.1. “ТТТ” ХХК-ийн ИТА нар ХАБЭА-н талаар явуулж буй үйл ажиллагаа Монгол улсын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, замын хөдөлгөөний аюулгүй

Үйлдвэрийн бүсэд замын хөдөлгөөнд оролцох журам	СҮАЖ-ҮБЗХОЖ-008
	Хувилбар: 1

байдлын тухай хууль, дүрэмд хэрхэн нийцэж байгааг олж мэдэх, хэрэглэх, үнэлэх үүрэгтэй.

7.2. Энэхүү журмыг зөрчсөн ИТА, ажилтнуудад Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль, “ТТТ” ХХК-ийн дотоод журмын хүрээнд захиргаа удирдлагын алба, хяналтын хэсгийн эрх бүхий ажилтнууд хариуцлагын төлбөр ногдуулна.

7.3. Журмын хэрэгжилтэнд “ТТТ” ХХК-ийн ХАБЭА-н хэсэг хяналт тавьж ажиллана.